

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2018.09.25-2018.10.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын ИТХ, ЗДТГ болон аж ахуй нэгж байгууллагуудын “Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг”-ийг 2018 оны 09-р сарын 24-ний өдөр сумын төв талбайд зохион байгуулж нийт 6 байгууллагын 40 албан хаагч оролцож, давхардсан тоогоор 231 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлж, 287 брошур, гарын авлага тарааж, 7 өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч газар дээр нь шийдвэрлэсэн байна. Мөн ЗДТГ-ын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, хүнд суртал, цаг баримтлалын талаар санал асуулга авахад сайн үнэлэгдсэн байна.



“Малчдын нэг өдөр” өдөрлөгийг 2018 оны 09-р сарын 28-ны өдөр 2-р багийн малчдын дунд зохион байгуулж сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг тавьж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн иргэдийн санал бодлыг сонсон ажилласан. Мөн азын сугалаа сугалуулах, хөл бөмбөг, хөгжөөнт буухиа, АХА зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



Олон Улсын ахмадын баярын арга хэмжээг 9 дүгээр сарын 30-ны өдөр ШОХК, Страто ХХК -тай хамтран ШОХК-ийн урлаг зааланд зохион байгуулж хүлээн авалт хийж, 240 ахмад настанд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсан. Уг арга хэмжээний үеэр Монголын Ахмадын холбооны Хүндэт тэмдэгээр – 3 ахмад, сумын Засаг даргын

“Өргөмжлөл”-өөр 3 ахмад настан тус тус шагнагдсан. Мөн суманд үйл ажиллагаа явуулдаг 37 албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нийт 198 ахмад настанд хүндэтгэл үзүүлж, байгууллагад харьяалалгүй 39 ахмад настны судалгааг аймгийн ХХҮГ-т хүргүүлж хүндэтгэл үзүүлсэн.




Сум орон нутагт спортын хөгжлийг эрчимжүүлэх, иргэдийг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд “Архи, Тамхигүй орчин” спортын наадмыг 2018 оны 09 сарын 29-ний өдөр спортын 5 төрлөөр зохион байгуулж нийт 26 багийн 161 тамирчин оролцсон ба тэмцээний төрөл тус бүрд 1-3-р байр, нийлбэр дүнгээр эхний 3 байрыг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагналаа. Мөн шилдэг багууд аймагт зохион байгуулагдах МУ-ын Ерөнхий сайдын нэрэмжит “Иргэдийн спортын наадам”-д оролцох эрх авч спортын 5 төрлөөс 2 алт, 4 мөнгөн, 1 хүрэл медаль тус тус хүртэн багийн дүнгээр Тэргүүн байр эзэлж цомын эзэн болсон.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Цэвэр агаар” арга хэмжээг зохион байгуулж сумын наадмын талбайгаас сумын төв талбай хүртэл алхаж идэвхтэй дасгал хөдөлгөөн хийж, спортын 3 төрлийн тэмцээнийг зохион байгуулсан.



Сумын хэмжээнд цэрэг татлагын ажлыг 10 сарын 17-ны өдөр зохион байгуулж 18-26 насны 40 залуус хамрагдаж 18 залуучууд эмчийн үзлэгт тэнцсэн байна.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2018 оны 10-р сарын 25-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	35709000	32529000
2.	ЗДТГ	235959000	234279226

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	Эрүүл мэндийн төв	264641500	259341500
2.	Соёлын төв	46140600	44138603
3.	3-р сургууль	639488900	631916843
4.	3-р цэцэрлэг	320400500	310581930

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Засгийн газрын 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр 8 зорилтын хүрээнд 19 ажил төлөвлөн хэрэгжүүлж 3-р улирлын байдлаар 64,7 хувийн хэрэгжилттэй ажиллаж байна.

Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулан сумын ИТХ-д хүргүүлээд байна.

Сумын 18-26 насны залуучуудад Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудаар гарын авлага бэлтгэн 28 залуучуудад тарааж ажилласан.

Засаг даргын тамгын газрын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” ажлын 3-р улирлын тайланг сумын ИТХ-д тайлагналаа.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ:

3-Р АХЛАХ СУРГУУЛЬ

”School police” эцэг эхийн эргүүлийг 9 дүгээр сарын 10 ны өдрөөс эхлэн хуваарь гарган өдөр бүр тогтмол хийлгэж байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх 19 ажлыг төлөвлөөд байна.

Сургуулийн дотоод журамд албан үүргээ гүйцэтгэх явцад ажлын цагаар согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглосон заалт байдаг тул нэвтрүүлэх, хадгалахыг хориглосон заалтыг 2018 оны 09 дүгээр сарын 10 нд нэмэж тусгасан.

Монгол улсын БСШУС-ын сайдын 2018 оны 09 дүгээр сарын 28 ны өдрийн А/608 тоот тушаалын “Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам”-ыг нийт багш, ажилтан, суралцагч, эцэг эхчүүдэд сурталчилан танилцуулж үүний хүрээнд хийх ажлын төлөвлөлт гарган ажиллаж байна.

Багш нарын мэдээллийн технологитой харилцах чадвар,заах арга зүйг сайжруулах, харилцан туршлага солилцох зорилгоор “Мэдээлэл технологийг математик, физикийн хичээлд хэрэглэх нь” ур чадварын уралдааны 1 дүгээр шатыг сургууль дээрээ зохион байгуулж Физикийн багш Э.Долгормаа, Математик мэдээлэлзүйн багш Ж.Баярцэцэг нар

шалгарсан. Уг уралдаанд шалгарсан багш нар БСУГ-аас зохион байгуулах 2 дугаар шатны ур чадварын уралдаанд оролцохоор бэлтгэж байна.

“Гавьяат багш зөвлөж байна” залуу багш нарын зөвлөгөөнийг залуу багш нараа ажлын дадлага туршлагатай болгох зорилгоор БСУГ, Шивээговь сумын ерөнхий боловсролын сургууль хамтран 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр сумын ерөнхий боловсролын сургуулийн урлаг зааланд зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд Говьсүмбэр аймгийн гавьяат багш М.Сэртэв, Дашням нар урилгаар оролцож залуу багш нартаа туршлагаасаа хуваалцан үнэтэй зөвлөгөө өглөө. Мөн З.Цолмонбаяр багш “Амжилтанд хүрэх шалгуур” “Хүний хөгжил” сэдвүүдээр илтгэл тавьж, залуу багш нарыг Шивээ-Овоо ХХК-ны үйл ажиллагаатай танилцуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймаг орон нутгийн удирдлагууд, ахмад багш нар болон сургуулиудын залуу багш зэрэг нийт 110 хүн хамрагдлаа.



2018-2019 оны хичээлийн жилийн оролцооны бүлэг, дугуйлан секцын нээлтийн үйл ажиллагааг 2018 оны 10 дугаар сарын 15-нд зохион байгуулж 24 багшийн 29 дугуйлан секцэнд 702 суралцагч, 12 оролцооны бүлгийн 354 суралцагч хамрагдахаар бүртгүүлээд байна. Оролцооны бүлгүүд энэ хичээлийн жилд хийхээр төлөвлөж буй ажлаа төлөвлөн тангарагаа өргөлөө.



Аймгийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газраас “Эерэг хандлага – Эрүүл оюутан” аяны хүрээнд хорт зуршлаас сэргийлэх “Дэвжээ” тэмцээнийг 2018 оны 10 дугаар сарын 17-нд оролцооны бүлгийн ахлагч нарын дунд зохион байгуулсан тэмцээнд 3-р сургуулийг төлөөлөн оролцсон “Оюуны ундраа” баг III байр эзэллээ. Уг арга хэмжээгээр суралцагчдад НҮБ-ын “Хүүхдийн эрхийн конвенц, МУ-ын “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөтэй бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль” зэрэг хуулиудыг сурталчилж ажилласан.



“Тогтвортой хөгжлийн боловсролд эцэг эхчүүдийн оролцоо “ сэдвээр өртөөчилсэн сургалтыг сургуулийн эцэг, эх, багш, ажилтнуудад зохион байгуулсан.

ЭЕШ-ийн жилийн төлөвлөгөө гаргаж батлуулан 7 судлагдахуунаар 3 удаа авч дүн мэдээг нэгтгэн төгсгөгчдийн буланд байршуулан танилцуулсан.

2018-2019 оны хичээлийн жилд “Математик” сонин болон Монголын Математикийн багш нарын холбоо, IQ сэтгэх чадварын төвтэй хамтран IQ сургалтыг зохион байгуулж байна. Энэ хичээлийн жилд сэтгэх чадвар IQ дугуйланд I – V ангийн 13 бүлгийн 154 суралцагч, VI-VII ангийн 17 суралцагч нийт сургуулийн хэмжээнд 171 суралцагч IQ сэтгэх чадварын дугуйланд хамрагдан 2018 оны 10 дугаар сарын 05-наас хуваарийн дагуу хичээллэж эхлээд байна.

Б.Учирал багштай төгсөх 12 дугаар ангийн суралцагчид “**Сурагчийн нэг өдөр**” арга хэмжээг 10 дугаар сарын 4-нд зохион байгуулж 12а, 11а ангийн суралцагчид мэргэжлийн болон анги удирдсан багш, удирдлага болж сургуулийн 1 өдрийн үйл ажиллагааг өөрсдөө явуулснаар сургалтын байгууллагад ажилладаг янз бүрийн мэргэжилтэй хүмүүсийн ажлыг хийснээр боловсролын салбарт ажиллах суралцагчдад ажил мэргэжилийн чиг баримжаа олгоход дөхөмтэй байлаа.



Говьсүмбэр аймагт 9 дүгээр сарын 29-нд зохион байгуулагдсан Зүүн бүсийн математикийн олимпиадад 3-р сургуулийн 6-12-р ангийн 17 сурагч оролцож 106 ангийн суралцагч П.Эрдэнэбаяр 3 дугаар байр эзэлж хүрэл медаль хүртсэн. Мөн 7 суралцагч 1-7 оноо авч амжилттай оролцлоо.

Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан “**Өсвөрийн аврагч-2018**” тэмцээнд сургуулийн өсвөрийн аврагч багийн чиглүүлэгч багш С.Дуламсүрэн ахлах ангийн 7 суралцагчидтай баг бүрдүүлэн оролцож 3 дугаар байр эзэлсэн.

Сургуулийн спорт заалны сантехникийн хэсэгчилсэн засварын ажлыг 2018 оны 10 сарын 12-19-ны хооронд урсгал засварын 912712 төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэн халаалтаа авсан.



СОЁЛЫН ТӨВ



Улаанбаатар хотын “Хүүхэлдэйн театр”-ын Алиалагчийг урьж Сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад түүний уран бүтээлийг толилууллаа.

Сумын АА бүлгийн 6 жилийн ойн баярын арга хэмжээг сумын соёлын төвтэй хамтран 10-р сарын 14-ний өдөр зохион байгуулсан.

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 160 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 11 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

10-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 23 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. 2018 оны 10-р сарын байдлаар 50 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг хүлээн аваад байна.

Иргэдээс 10-р сард 150 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн. Өргөдлийн тоо өссөн нь уурхайн байр хувьчлагдаж байгаатай холбогдуулан баг дотор шилжилт хөдөлгөөний бүртгэлийг өссөн дүнгээр нийт 247 иргэн хийлгэсэн байна. Мөн өөр аймгаас суманд шилжин ирсэн иргэдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2018 ОНЫ 10 САРЫН МЭДЭЭ

/Өссөн дүнгээр/

	м/ д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	70				70	35	35
Төрсөн эх	2	70				70		70
Бүртгүүлсэн гэр бүл	3	21				21	21	21
Нас баралт	4	14				14	8	6
Цуцалсан гэр бүл	5	6				6	6	6
Үрчлэгдсэн хүүхэд	6	3				3	2	1
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	127				127	62	65
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	82				82	42	40

ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2018.10.24

Д/д	Үйлчилгээний нэр төрөл	2018 оны 10-р сар			Бүгд	Бүгд		Тайлбар	
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд		Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд	Тоо		
		Нэг бүрийн үнэ	Тоо						
1	Эцэг тогтоосны бүртгэл	2500	3	7500					
2	Гэрлэлтийн бүртгэл	2500	1	2500					
3	Сум доторх шилжилт	1500	43	64500	1000	43	43000		
4	Үрчлэлтийн бүртгэл	2500	1	2500					
5	Гэрлэлт цуцлалт	2500	1	2500					
6	Гэрлэлтийн гэрчилгээ дахин	5000	1	5000					
7	Өөр аймаг шилжин явсан	2500	4	10000	1000	4	4000		
8	Төрсний гэрчилгээ дахин	5000	1	5000					
Дүн		99500			47000				
Д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд	Бүгд		Тайлбар	
		Нэг бүрийн үнэ	Тоо			Нэг бүрийн үнэ	Тоо		
		7	Иргэний үнэмлэх	15000	29	435000	3300		29
Дүн		435000			95700				
Нийлбэр дүн		534500			142700				
Нийт орлогын дүн		677200							

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ

“Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 15 өрхийн 9, 10-р сарын 2200000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан олголоо.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн дагуу бүрэн хараагүй, хэлгүй дүлий, байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй 27 иргэнд /иргэн буюу хүүхдэд/ орон сууцны хөлс төлөх, гэрт түлш худалдан авахад шаардагдах 3780000 төгрөгийн мөнгөн тусламжийг олгосон байна.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд бүлгийн зохион байгуулалттайгаар задгай талбайд төмс хүнсний ногоо тариалсан бүлэг 2,5 тн ургац хураан авсан.




Нийгмийн халамжийн тухай хуулийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний амьдралын итгэл үнэмшил олгох сургалтыг 2018 оны 10-р сарын 18, 19-ний өдрүүдэд “Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ-тай хамтран 25 ахмад настанд зохион байгууллаа.



НИЙГМИЙН БОДЛОГО

Аймгийн боржигин өв музейтэй хамтран төрийн албан хаагчдын дунд “Угийн бичиг хөтлөлт” сургалтыг зохион байгуулж, сумын төрийн албан хаагчдын 70% буюу 105 албан хаагчид хамрагдсан байна.



Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 2 албан байгууллага, 2 ахмад настан, 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөд 60 чацаргана, 40 үхрийн нүд жимсний суулгацыг үнэ төлбөргүй олголоо.



Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Хорт зуршлаас урьдчилан сэргийлье” арга хэмжээг 2018 оны 10 сарын 09-ний өдөр ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж 300 сурагч хамрагдлаа.



БАЙГАЛЬ ОРЧИН

Монгол улсын Ойн тухай хууль болон Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн хүрээнд 2018 оны 10-р сарын 13-нд “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг сумын хэмжээнд зохион байгуулж 21 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нийт 8 төрлийн 490 мод тарьж сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Үүнд: ЗДТГ-20, сургууль-



Байгаль хамгаалах “намрын аян”-ы хүрээнд зохион байгуулагдаж буй “Хог хаягдал цэвэрлэх марафон уралдаан”-ны удирдамжийн дагуу Шивээговь сумын ерөнхий боловсролын сургуулийн Эко клубын 50 гаруй гишүүд 10 сарын 18-ны өдөр сумын баруун хэсэг болох уурхайн контороос цааш 18 га талбайн 3 тн хог хаягдлыг түүж, ангилан ялгаж, төв хогийн цэгт ачиж зайлуулсан.



ЗДТГ нь 2018 оны 10-р сарын 01-нээс татварын байцаагчтай болж АБ, ААН айл өрхөөс хог хаягдал гаргасны төлбөрийг хураан авах ажлыг эрчимжүүлэн ажиллаж 10-р сарын 20-ны байдлаар ОНО-д хог хаягдлын хураамж 6626900 төгрөгийг төвлөрүүлээд байна.

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

Улсын төсвийн 18 сая төгрөгийн хөрөнгөөр сумын 2 дугаар багийн нутаг Тарвагат дулааны энгэр гэдэг газарт бэлчээрийн зориулалтаар шинээр гүний худаг гарган улсын комисст хүлээлгэн өглөө.



“Иргэдийг малжуулах журам”-ын дагуу 10 дугаар сарын 12-ны өдөр цөөн мал бүхий 4 малчин өрхөд тус бүр 40 хонь, 20 ямааг гэрээгээр хүлээлгэн өгч малжуулах ажлыг зохион байгуулсан.

Сумын Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 05 өдрийн А/147 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг 2018 оны 10 дугаар сарын 08-ний өдрөөс эхлэн зохион байгуулж 10-р сарын 25-ны өдрийн байдлаар 58 өрхийн 21471 толгой хонийг тарилгад хамруулаад байна.

Сумын Засаг даргын А/146 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 10 дугаар сарын 08 өдрөөс эхлэн сумын 2-р багийн нутаг дэвсгэрийн 8 цэгийн 2000 га газарт энгийн болон механик аргаар хийж гүйцэтгэсэн.



Бог малд ангилалт, баталгаажуулалт, ээмэгжүүлэлт хийх ажлыг 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж ангилалт баталгаажуулалтыг 3000 хээлтэгч малд, ээмэгжүүлэлтийг 615 малд хийж гүйцэтгэсэн.



Төмс 2,8 га талбайд тариалж 28,6 тн ургац, хүнсний ногоо 3 га талбайд тариалж 64,2 тн ургац хураан авч иргэдийн хүнсний ногооны хэрэгцээнд нийлүүлээд байна.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сумын засаг даргын 2018 оны А\152 тоот захирамжаар золбин нохой, муур устгах ажлын хэсэг томилогдон ажиллаж Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн иргэн Г.Чинзоригтой гэрээ байгуулан 2018 оны 10-р сарын 16, 17-ны өдрүүдэд уг ажлыг зохион байгуулж 41 нохой, 13 муурыг устгаж ариутгал халдваргүйжүүлэлт хийж булсан.



Сумын өвсний фондыг нэмэгдүүлэхээр ОНХС-ийн 5 сая төгрөгийн хөрөнгөөр 798 боодол Өвсийг худалдан авахаар улаанбаатар хотын иргэн Т.Батнасангай гэрээ байгуулаад байна.

МЭДЭЭГ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ